

зорилго биелдэг гэж гадны судлаачид бичсэн байна.

Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхэд эрх зүйн бус шинжлэх ухаан болох сэтгэл судлал, сурган зүй, эдийн засаг, менежментийн шинжлэх ухааны судалгаааны аргатай нягт уялдаатай хөгжүүлэн, ямар байдлаар яаж холбогдох нь ял эдэлж буй субъектүүдийн эрхийн байдал, ялангуяа ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрхэн боловсронгуй болгохоос ихээхэн шалтгаална. Сэтгэл судлалын шинжлэх ухааны үндсэн зарчмууд бүх төрлийн ял эдлэх, эдлүүлэх ажиллагаанд оролцогч субъектүүдэд тохирч байхад, ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны аргыг хорих ял эдлэгсэдэд хэрэглэхэд илүү үр нөлөөтэй байх жишээтэй байдаг ажээ.

**M.ЦЭНД**


*Оросын Холбооны Улсын Дотоод Явдлын Яамны Москвагийн их сургуулийн адъюнкт, хурандаа*

## ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ ХОЙШЛУУЛШГҮЙ АЖИЛЛАГАА

Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, нас баралт, орголтын тоон үзүүлэлтүүдийг судлан үзэхэд 2000 онд ялтны дундаас үйлдэгдсэн гэмт хэрэг 164, зөрчил 1265, нас баралт 97, орголт 333 байсан бол 2008 онд гэмт хэрэг 28, зөрчил 851, нас баралт 15, орголт 10 болж буурсан нь ШШГБ-н үйл ажиллагааны амжилтыг илэрхийлсэн сайн үзүүлэлт хэдий ч ЭБШХуулийн 172-р зүйл буюу хорих байгууллагад гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах, “хойшлуулшгүй ажиллагаа” явуулах мэдлэг, мэргэжлийн ур чадвартай байхыг биднээс шаардаж байна.

д/д	Он	Гэмт хэрэг			Бүгд	Зөрчил		
		Хорих анги	ЦХБ	БЯЭБ		Хор анги	ЦХБ	БЯЭБ
1	2000	164			164	1265		1265
2	2001	178			178	1159		1159
3	2002	77			77	1290		1290
4	2003	29	5		34	953	54	1007
5	2004	10	8		18	854	196	1050
6	2005	23			23	858	170	13
7	2006	4			4	532	4	540
8	2007	27	2		29	736	123	859
9	2008	24	4		28	773	78	851

**Нас барсан, оргосон ялтан, сэжигтэн, яллагдагчдын судалгаа \1997-2008 он\**



Хорих байгууллагын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, учралын тухай гомдол мэдээллийг шалган шийдвэрлэхийн тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулсан хэм хэмжээнүүдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл ШШГЭЗҮЙ, ЭБШЭЗҮЙ нь хуулийн дараах заалтуудаар

уялдан хэрэгжинэ. Үүнд:

Хойшлуулшгүй ажиллагаа явуулах \ЭБШХ-н 172-р зүйл\, сэжигтэн яллагдагчид цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авах \59,68-р зүйлүүд\, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтооолыг гүйцэтгэх \330-р зүйл\, торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах \332-р зүйл\, өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлөх \333-р зүйл\, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах, ялаас чөлөөлөх \334 дүгээрзүйл\, гянда \335-р зүйл\, торгохялыг баривчлах, хорих ялаар солих, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх \336-р зүйл\, эмнэлгийн байгууллагад байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох \337-р зүйл\, тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх \339-р зүйл\, ял

№	Он	Жилийн эцэст хоригдогсдын тоо			Нас барагсдын тоо				Оргодлын тоо			Бүгд
		Ялтан	Сэжигтэн	Нийт	Хорих	БЯЭБ	ЦХБ	Бүгд	Хорих	БЯЭБ	ЦХБ	
1	1997	6069			362			362	421			421
2	1998	6178			242			242	403			403
3	1999	6376			182			182	443			443
4	2000	5662			97			97	333			333
5	2001	6642			53			53	174			174
6	2002	6564	1151	7715	39			39	73			73
7	2003	5999	1666	7665	34	1	5	40	68	3	18	89
8	2004	6288	1810	8098	27		5	32	32	1	16	49
9	2005	7058	1848	8906	30		7	37	41		11	52
10	2006	5179	1561	6740	29		1	30	23	1	11	35
11	2007	6149	1771	7920	16		1	17	17		1	18
12	2008	6289	1869	8150	13		2	15	10			10